

ЭРХЭМ ЗОРИЛГО ЗОРИЛТУУДЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХУРААНГУЙ

Оюу Толгой Хяналт ТББ нь 2012-2013 онд эрхэм зорилгын хүрээнд *хүний эрх ба амьдрах орчныг хамгаалах* өргөн хүрээ бүхий үйл ажиллагаа хэрэгжүүлж ирсэн.

Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээг хэрэгжүүлэх явцад хүний эрх, байгаль орчны стандартын нийцэлд хяналт тавьж энэ хүрээний асуудлуудаас зөвхөн уламжлалт байгалийн нөөц буюу бэлчээр болон усаар хангагдах эрхийг хангах үүрэгт үйл ажиллагааг төвлөрүүлж ирсэн. Энэ нь тус ТББ нь санхүү мөнгөний хомс байдлаас хүний нөөцийн хүчин чадал, чадавхаа нэмэгдүүлэх боломжгүй хязгаарлагдмал нөөцтэй ажиллаж ирсэнтэй юуны өмнө холбоотой болно.

Олборлох салбар, түүний дотор стратегийн орд газрын үйл ажиллагаанд *нийцлийн мониторинг хийх чадавхыг хөгжүүлэхэд* чиглэсэн үйл ажиллагаанд ТББ-дын хүрээнд олборлох салбарын олон улсын стандарт, КНХ-ын тайлагнал ба хариуцлагын механизмуудын тухай хэдэн удаагийн сургалт, мэдээлэл түгээх ажил хэрэгжихээс хэтрээгүй. ОТ төслийн зөрчлийг баримтжуулж гомдол гаргах, гомдлуудыг барагдуулах явцад үндэслэн ТББ-ын хүрээнд чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа төлөвлөсөн боловч Рио Тинто\Оюу Толгой ХХК-аас гомдлын явцыг нийтэд мэдээлэхгүй байх шаардлага тавьснаар бодит жишээнд үндэслэсэн сургалт явагдах боломжгүй болсон.

Орон нутагт иргэний нийгэм, ТББ-ын хөгжлийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд Ханбогд, Манлай, Цогтцэций, Хатанбулаг сумдад ажиллаж буй ТББ-ыг судалж, сургалтандаа хамруулж ажилласан. Хамтын ажиллагаа хөгжүүлэх чиглэлээр Их говийн ус хамгаалал ТББ, Говийн газар шороо, Гучин ус ТББ-тай ажиллаж гомдлын асуудлуудад сүүлчийн хоёр ТББ-тай хамтран ажиллаж байна. Орон нутгийн ТББ-ыг дэмжихэд хөрөнгө мөнгө болон хүн хүчнээс гадна урт хугацаанд тогтвортой ажиллах боломж муу, нутгийн иргэдийн зөвхөн өөрийн амьжиргаанд өөрчлөлт бий болгох үр дүн харсан жигд бус оролцооноос шалтгаалан үр дүн сул байна.

Хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг олон улсын стандартад нийцүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах зорилтын хүрээнд БОННУ тухай хуулийг хэлэлцэхэд УИХ-ын ажлын хэсэгт орж ажиллаж БОННУ-ний хүрээнд нийгмийн ба эрүүл мэндийн үнэлгээг оруулах, энэ үнэлгээний журмыг ЗГ батлах заалт оруулахад хувь нэмэр оруулсан. Мөн Усны тухай хууль, Газар албадан чөлөөлөх, АМТ, Гол усны эх, ойн сан бүхий газар хайгуул, олборлох үйл ажиллагааг хориглох тухай хуулийн нэмэлт өөрчлөлт зэрэг төслүүдэд санал бэлтгэх, хэлэлцэх ажиллагаанд оролцох хэлбэрээр ажиллаж ирсэн.

Зорилтуудаа хэрэгжүүлэхэд *олон улсын сүлжээнд нэгдэх*, експертуудыг татан оролцуулах болон энэ хүрээнд Дэлхийн Банк, ЕСБХБ болон Оюу Толгойд хөрөнгө оруулагч орнуудын засгийн газруудад нөлөөлөх ажиллагааг хангалттай хийж ирсэн нь үр дүнгээ өгч байна.

Мөн *хүний эрхийг хамгаалах* чиглэлийн олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, бизнес ба хүний эрхийн бодлого боловсруулах сургалт, чадавх бэхжүүлэх арга хэмжээнд оролцож өөрийн чадавхыг нэмэгдүүлж УИХ, ЗГ-ын яамдад энэ асуудлаар асуулга тавих, бодлого боловсруулахыг шаардах ажлыг эхлүүлсэн.

ДҮГНЭЛТ:

Оюу Толгойн Хяналт ТББ нь 2010 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн гурван жилд олборлох салбарын мониторинг, хүний эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаатай ИНБ-ын хувьд олон улсын тавцанд ч, үндэсний болон орон нутгийн хэмжээнд ч нэр хүндээ баталгаажуулж хүлээн зөвшөөрөгдөж чадсан үндсэн амжилтанд хүрсэн.

Оюу Толгойн Хяналт ТББ зөвхөн ОТ-н мониторингоор үйл ажиллагааг хязгаарлахгүй байхыг шаардсан ИНБ-ын хүлээлт бий болж хүчин чадлаа нэмэгдүүлэх, үүний тулд хөрөнгө босгох ажиллагаанд анхаарлаа төвлөрүүлэн ажиллах зайлшгүй шаардлага тавигдаж байна.

Дорноговь, Говь-Алтай аймгуудад ажиллах тодорхой хүсэлт ирсэн. Баянхонгор, Сүхбаатар аймгуудад ажиллах үүрэгтэй гэсэн хүлээлт зэргээс харахад орон нутагт ажиллах арга хэлбэрийг олж боловсруулах шаардлага тавигдаж байна.

Үүний зэрэгцээ олборлох салбар, бизнес ба хүний эрхийг хамгаалахад чиглэсэн олон улсын нөлөөлөл, бодлого боловсруулах үйл явцад оролцох үйл ажиллагаа эхлүүлсний хувьд энэ чиглэлийн үйл ажиллагаанд оролцох төлөвлөлт, чадавх бэхжүүлэх шаардлага тавигдаж байна.

2012-2013 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ

2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Оюу Толгойн ХО-ын гэрээг МУ-ын хууль, ОУ-ын хуулийн зарчмуудад нийцсэн эсэхийг судлах, баримтжуулах

Оюу Толгойн төслийн ХО-ын Гэрээг өөрчлөх асуудлаар хийгдэж буй хэлцлийн мэдээлэл цуглуулах, ажиглах, гэрээг өөрчлөх, шударга болгох, тогтворжуулалтын хугацааг олон улсын жишигт нийцүүлэх шаардлагын асуудлуудаар УИХ, Засгийн газар, Дэлхийн Банк болон хэвлэлд мэдээлэл өгөх зэргээр нөлөөллийн ажил хийгдэж ирсэн. Мэдээллүүдийг манай www.minewatch.mn сайтаас татаж үзэж болно.

- Оюу Толгойн ХО-ын гэрээний хэрэгжилтэд нийцлийн хяналт тавих, эрхийг хамгаалах үйл ажиллагааныхаа чиглэлийн хүрээнд Оюу Толгой төслийн нөлөөллийн бүсэд амьдардаг малчдын нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын гэрээнд үнэлгээ, хэрэгжилтэд мониторинг хийж зөрчлүүдийг тогтоосон. Дэлхийн банкны групп (ДБГ)-ийн Олон улсын Санхүүгийн Корпорац (ОУСК)-ийн нүүлгэн шилжүүлэлт, сөрөг нөлөөллийн нөхөн олговрын бодлого ба стандартыг зөрчсөн асуудлаар хоёр гомдлыг Говийн газар шороо ТББ-ын хамт ОУСК-ийн гомдол хүлээж шийдвэрлэх нэгжид гаргаж гомдол хэлцэх явцад зөвлөгөө үзүүлж ирсэн.

I. Оюу Толгойн төслийн нөлөөллийн бүсэд мониторинг\тандалтын ажил:

1. 2012 оны 4 дүгээр сарын 22-27-ны өдрүүдэд Оюу Толгойн төслийн нөлөөллийн бүсэд мониторинг
2. Хүний эрхийн стандарт, олон улсын хамгааллын механизмуудын талаарх сургалтууд нөлөөлөлд өртсөн малчдад хийх, гомдол гаргах үндэслэл боловсруулах үйл ажиллагаа

3. 2012 оны 9 дүгээр сард гомдол боловсруулах ажил эхлүүлсэн. Мөн үеэр олон улсын гомдлын механизмд хандах, хэлцэл хийх
4. 2012 оны 10-р сарын 12-нд Токио хотноо болсон ДБГ-ийн Намрын тайлангийн хурлын үеэр Ханбогд сумын малчдыг Оюу Толгой уурхайн лицензтэй талбайгаас нүүлгэх 2004 оны Нүүлгэн шилжүүлэлтийн гэрээ, нөлөөллийн бүсэд орших өрхүүдэд сөрөг нөлөөллийн нөхөн олговор олгох 2011 гэрээнүүдэд малчдын эрхийг бүдүүлгээр зөрчсөн асуудлаар ОУСК-ийн Нийцэл, Зөвлөх ба Эрхийг хамгаалагч (CAO)-ийн газрын дарга, ДБГ-ийн Дэд ерөнийлөгч Маргарет Тэйлорт гаргасан гомдлыг өөрт нь гардуулсан.
5. 2012 оны 10 дугаар сарын 18-нд ОУСК-ийн Омбудсман Мэг Тэйлорын оролцоотой Гомдлын механизмын тухай сургалтыг CAO-ийн багтай хамтран зохион байгуулав.
6. 2012 оны 11-р сарын 24-29-нд ОУСК-ийн CAO-ийн гомдлын мэргэжилтнүүд ирж Ханбогд сумын малчдын гаргасан гомдлын дагуу судалгаа, баримтжуулалтын ажил хийх явцад оролцож нэмэлт мониторинг, мэдээлэл цуглуулалт хийв.
7. Мөн үеэр Банкны мэдээллийн төв (BIC USA) түнш ТББ-ын Монголыг хариуцсан ажилтан Сара МкНийл ирж гомдол гаргагчид, CAO-ийн багтай уулзаж гомдол хэлэлцэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахаа мэдэгдсэн.
8. 2012 оны 11 дүгээр сарын 20-23-ны өдрүүдэд Нийцлийн Хяналтын Нэгж \НХН\-ийн сургалтын явцад мэдээлэл цуглуулалт, бэлгийн дарамтын асуудлаар мэдээлэл авах зэрэг мониторингийн ажил хийгдсэн.

II. Зөрчлийг баримтжуулах, арилгуулах, эрхийг хамгаалах талаар:

Олон улсын байгаль орчин ба хүний эрхийн стандартад нийцээгүй үйл ажиллагаанаас учирсан хохирлыг барагдуулах, нөлөөллийг бууруулах зорилгоор олон улсын шүүхийн бус гомдлын механизм хэрэглэх, эрхийг хамгаалах чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлсэн.

2012 оны 10 дугаар сарын 12-нд эхний гомдлыг ОУСК-ийн Эрхийг хамгаалагч (Ombudsman) Мейган Тэйлорт өөрт нь гардуулсан. Гомдолд 2004 оны нүүлгэн шилжүүлэлт, 2011 нөлөөллийн нөхөн олговрын гэрээнд малчдад учирсан хохирлыг зохистой үнэлээгүй, нөхөн олговрыг бүрэн гүйцэд шудрагаар олгоогүй асуудлуудыг тусган а\ сөрөг нөлөөллийг үнэлэх аргачлалыг өөрчлөх, б\ бэлчээргүй болсон малчдын амьжиргааг шийдвэрлэх хөтөлбөр, в\ уламжлалт нүүдэлч ахуй соёл алдагдахаас хамгаалах, дан компанийн эрх ашгийг хамгаалсан гэрээг өөрчлөх зэрэг санал гаргасан.

Гомдлын мөрөөр судалгаа хийх баг 2012 оны 11-р сард ирж ажиллаж тайлангаа гаргаад 2013 оны 3-р сараас гомдолд холбогдогч талуудад зуучлан эвлэрүүлэх замаар гомдол барагдуулах ажил эхэлсэн. Гомдлыг хэлэлцэх үйл ажиллагаанд 2013 оны 2-р сараас ОУСК-ийн CAO-гийн мэргэжилтэн Рая Кадырова тэргүүтэй баг зуучилж ажилласан. Үргэлжлэлийг 2013 оны тайлангийн хэсгээс уншина уу.

2013 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ОУСК-ИЙН ГОМДЛЫН МЕХАНИЗМД МЭДҮҮЛСЭН ГОМДЛЫН ЯВЦ

2013 оны 2 дугаар сарын 22-нд Ундайн голын голдрилыг нутгийн малчдын эсэргүүцлийг үл харгалзан гүйцэтгэж хохирол учруулж байгаа тухай гомдол гаргасан. Гомдолд Ундайн голын голдрилыг өөрчлөх ажлыг даруй зогсоож учирсан хохирлыг барагдуулах шаардлага тавьсан.

2013 оны 3-р сараас гомдол гаргасан малчдыг төлөөлөх баг сонгох, САО-ийн эвлэрүүлэх үйл ажиллагааны зарчимд сургах, багаар ажиллах бэлтгэлийг хангах зэрэг ажлууд хийгдсэн.

2013 оны 4-р сараас хоёр гомдлыг нэг үйл явцын хүрээнд компанитай хэлэлцэхээр тохирсон нь компани Ундайн голын голдрилыг өөрчлөх ажлаа түргэтгэх, хаалгахгүй байх зорилго нөхцөл тавьснаар “мэдээллээр хангах” нэртэй уулзалтууд хийгдэж хэлцэл эхэлсэн.

Багуудын хурлаас сонгогдсон малчдын төлөөлөл |МТ| дөнгөж 7-р сард анхны удаа гомдлуудын асуудлаа тайлбарлах, ямар хохирол учраад байгааг таниулж Ундайн голын голдрилыг өөрчилснөөс малчдын ус ба бэлчээрийн хүртээмжид учрах хохирлыг үнэлүүлэх, бэлчээрийн тоо ба чанарын үнэлгээ хийлгэж гомдол гаргасан өрхүүдийн хохирлыг хэмжих аргачлал боловсруулахад ашиглах санал гаргасан.

Бүтэн жил, сар бүр, зарим үед сард хоёр удаа САО-гийн зуучлалтай уулзаж хэлцэл хийж ирсний дүнд хоёр гомдлын мөрөөр Ундайн голын голдрилыг өөрчилсөн, Бор-Овоогийн задгайг ширгээсний нөлөөллийн мэргэжлийн үнэлгээг хөндлөнгийн мэргэжилтэн \ХШБ\-ээр хийлгэхээр тохирч, ажлын даалгавар тохирох, мэргэжилтнүүдийг сонгох ажил олон сар үргэлжилж 11 дүгээр сард мэргэжилтнүүд Ханбогдод ирж ажилласан.

2004 оны нүүлгэн шилжүүлэлт, 2011 нөхөн олговрын гэрээний зөрчлүүдийн асуудлаар гаргасан гомдлын дагуу антропологичийн туслалцаатай бэлчээрт учирсан хохирлыг гаргуулж улмаар мал маллагаа бүхий амьжиргааны сөрөг нөлөөллийг тогтоолгох санал гаргаж хэлцэл олон сар үргэлжилсээр тодорхой үр дүнд хүрээгүй байна.

2013 оны мониторингийн ажлын хүрээнд УБ-Манлай-Ханбогд замын нөлөөллийг судалж баримтжуулах, малчдын гомдлыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх ажил хийгдэж 7-р сарын 1-нд ЕСБХБ-ны дэд ерөнхийлөгч тэргүүтэй төлөөлөлчид УБ-т айлчлах үеэр гардуулсан. Банкны Гомдлын механизм \РСМ\-ын баг ирж гомдлын мөрөөр судалгаа хийгээд тайлангаа гаргаж Менежментэд танилцуулсан ч шийдвэр гаргаж чадалгүй 2013 гарсан.

- Судалгаа, нийцлийн хяналтын үр дүнд үндэслэн олон нийтийн нөлөөллийн ажил, сургалт хийх

Судалгаа, нийцлийн хяналт мониторингоор илрүүлсэн асуудлуудыг холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэх, олон нийтэд мэдээлэх, нөлөөллийн зорилгоор дараах асуудлуудыг гаргаж тавьсан болно. Үүнд:

I. Оюу Толгой төслийн БОННУ, Үйлдвэрлэлийн менежментийн төлөвлөгөөний үнэлгээ хийлгэх, тайланг бодлогын нөлөөлөл, олон нийтэд таниулах чиглэлээр хийсэн ажлууд:

2010 онд ОУСК-иас зээл авах компанид хийдэг төслийн үнэлгээ хийгдэж эхэлснээр Оюу Толгой төслийг хэрэгжүүлэгч Рио Тинтогийн үйл ажиллагааг ОУСК-ийн стандарт нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж эхэлсэн. 2010 оны 10-р сард ОУСК-ийн зээлийн судалгааны багт ОТ-н БОННУ нь олон улсын стандартад нийцэхгүй байгааг анхааруулсан албан тоот гардуулж тус ТББ-ыг энэ төсөлд хяналт тавих сонирхогч талаар бүртгэхийг хүссэн.

Түүнээс хойш мониторингийн тайлангуудад тусгасан зөрчлүүдийг ОУСК-д мэдээлэх, ОУСК-ийн зээлийн судалгааны багийн мэдээллийг авах, шинээр олон улсын стандартад нийцүүлсэн БОННУ хийлгэхийг шаардсаар ирсэн.

2012 оны 8-р сард Оюу Толгой төслийн шинэчилсэн, олон улсын стандартад нийцүүлсэн БОННУ-ний тайлан нийтэд тавигдснаар түүний үнэлгээний ажил эхэлсэн. Энэ төслийн санхүүжилтийг Дэлхийн банкны группийн ОТХОБА, ОУСК, ЕСБХБ, АНУ-ын ЭКСИМ, Австралийн EFIC, Канадын Экспортын агентлаг, Герман ба бусад улсад бүртгэлтэй арилжааны банкууд оролцохоор зарласан тул тэдгээр орнуудад олон улсын санхүүгийн байгууллага (IFIs), Рио Тинто болон уурхайн компаниудын үйл ажиллагааг хянадаг ТББ-ын мэргэжилтнээс бүрдсэн багаар хяналт тавиулах ажлыг зохион байгуулав.

Оюу Толгой төслийн БОННУ-ний шүүмж “A Useless Sham” тайланг 2012 оны 12-р сард OT Watch, BIC, CEE Bankwatch, Accountability Council, London Mining Network, urgewald ТББ-ийн гарын үсэгтэй нийтэд түгээж нөлөөллийн ажил эхлүүлсэн. Энэхүү мэргэжлийн шинжээчдийн тайланд гарын үсэг зурсан ТББ-уудаас гадна бие даасан экспертүүд Роберт Гудланд, Пол Робинсон, Гордон Скотт, Даниэль Сонг, Женнифер Глисон, Марк Черняк, Хейди Вейскель нар ELAW, SRIC, Sierra Club, Пенсильванийн Их Сургууль зэргээс орж ажилласан. Тайлан ба түүнд холбогдох нөлөөллийн баримт бичгүүдийг www.en.minewatch.mn сайтаас татаж үзнэ үү.

БОННУ-нд уурхайн үйлдвэрлэл, нөөц ба хаягдлын менежментийн төлөвлөгөөнүүд буюу хамгийн чухал хяналт тавих баримт бичгүүд тусгагдаагүй байсныг нөлөөллийн ажлын гол болгон шаардсаар 2013 оны 9-р сард Оюу Толгой төслийн Менежментийн төлөвлөгөөнүүд (OMP) болон зээлдүүлэгчдийн хяналтын аудитын тайлан нийтэд танилцуулагдсан.

2013 оны 11-р сард OT Watch, BIC, CEE Bankwatch, SRIC, London Mining Network, Accountability Council, urgewald, Sierra Club, Jubilee Australia ТББ-даас дээрх төлөвлөгөөнүүдэд үнэлгээ хийж шүүмж гаргасныг ашиглан нөлөөллийн ажиллагаа эхэлсэн. Нөлөөллийн ажиллагааг Оюу Толгой төсөлд хөрөнгө оруулалт хийхээр зарласан улс орны засгийн газрууд, олон улсын банкууд, хувийн арилжааны банкууд, тэдгээрийн хувьцаа эзэмшигчдэд чиглүүлсэн болно. Дэлхийн банк, ЕСБХБ, ОУСК, Рио Тинтогийн хувьцаа эзэмшигчид, Европын холбоо, АНУ, Австрали, Их Британийн ЗГ-ын төлөөллүүдтэй биеэр очиж уулзах, бичгээр нэр цохон мэдээлэл ба шаардлагаа түгээх хэлбэрээр ажиллав. Холбогдох мэдээллийг мөн www.en.minewatch.mn сайтаас татаж үзнэ үү.

II. Газрын зөвшөөрөл, ТЭЗҮ, ХОГ-нд тусгагдаагүй асуудлууд

- Гүний Хоолой дахь усны нөөц газраас ус татах 75 км усны хоолой тавих, зам ба олон улсын нисэх онгоцны буудал барих зэрэг ажлыг эхлүүлсэн хойно иргэдээр хэлэлцүүлэх, газрын зөвшөөрөл авах зэргээр хуулийг зөрчих, иргэдэд тулган

зөвшөөрүүлэхийг шаардах хэлбэрээр ажилласаар байна. Гүний хоолойн суваг барьж байгуулах газрын зөвшөөрлийг авалгүй үйл ажиллагааг үргэлжлүүлж, ус хэрэглэж эхэлсэн нь 2014 оны 1-р сард Сумын газар ашглалтын төлөвлөгөөнд оруулж батлуулсан баримтаар тогтоогдсон болно. Оюу Толгой ХХК газрын зөвшөөрөлгүй барилгын ажил хийж байгаа асуудлаар ЗГ-ын яамд, компанид хандан тайлан авах, хуулинд нийцүүлэх шаардлага тавих ажлыг албан бичиг, и-мэйл, ХМХ болон санхүүжүүлэгч банкуудад хандах хэрэгжүүлсэн.

- Ундайн голын голдрилыг өөрчлөх ажлыг инженерийн зураг батлуулалгүй эхлүүлсэн, улмаар Бор-Овоогийн задгайг шилжүүлэх ажил 2013 оныг дуустал хэрэгжээгүй, нутгийн иргэдийг усан хангамжаар гацаасан зөрчил илэрсээр байгааг Дэлхийн банк, ОУСК, ЕСБХБ, Рио Тинтогийн хувьцаа эзэмшигчид, Европын холбоо, АНУ-ын Засгийн газар зэрэг хөрөнгө оруулалтад хамаарах газруудтай уулзаж мэдээлэл хийх, шаардлага тавих, малчдын гомдлыг хүргэх зэргээр нөлөөллийн ажил хийсэн.
- Хайрга, элс зэрэг барилгын материал олборлохдоо хамгийн ойр дөт байгааг нь байгаль орчны нөлөөллийг үл харгалзан Ундайн голын сайр, айлын өвөлжөө, хаваржааны дэргэдээс ухах, БОННУ хийлгэхгүй олборлолт хийх зэрэг зөрчил арилаагүй харин ч ЗГ-ын тэргүүн, холбогдох яамдын сайд нар хууль зөрчин “түр зөвшөөрлөөр” олборлолт хийлгэх журам тушаал гаргах зэргээр бүх шатандаа зөрчилтэй ажиллаж байна.
- Говь нутгийн ус энэ том уурхайг хангаж хүрэлцэхгүй гэсэн таамаглалыг няцаах судалгаа баримт бичгүүдээ нийтэд нээж, ил тод үйл ажиллагаа явуулах ХОГ-ний үүргээ хэрэгжүүлэхгүй байсаар байгаа асуудлуудыг орон нутгийн, үндэсний болон гадаадын ХМХ-ээр дамжуулан таниулах, нөлөөлөл ажил хийгдсэн.

III. Шилжүүлэн суурьшилтын асуудлууд

2004 онд шилжүүлэн суурьшуулсан “Оюу Толгой төслийн өрхүүд” нэртэй 11 өрхийн 7 өрхөөр орж шилжүүлэн суурьшуулснаас хойш амьдрал амьжиргааны байдал, Айвенхоу Майнзтай хийсэн гэрээний биелэлтийг гаргах судалгаа авсан. Шилжүүлэн суурьшуулсан өрхүүд, шилжүүлэлгүй нөхөн олговор олгох хөтөлбөрүүд нь нутгийн малчин өрхүүдийн амьжиргааг нөхөх, ирээдүйн нөлөөллөөс хамгаалах, усан хангамжийг тогтвортой байлгах чадваргүй байгаа нь хоёр гол учир шаалтгаантай байна. **Нэгдүгээрт**, Засгийн газраас малчдын амьжиргааг нөхөх, хамгаалах, нүүдэлч соёлын өв сан, бэлчээрийн эрхийг хамгаалах талаар бодлого байхгүй, компанид шаарлага тавьдаггүй өөгшүүлсэн практикаас шалтгаалж байна. **Хоёрдугаарт**, компани нь угаас аль болох бага зардлаар нүүлгэж, газар ба байгалийн бусад нөөцийг үнэ өртөг төлөхгүй, зөвшөөрөл авахгүй ажиллаж ирсэн дадалтай, түүнийгээ өөрчлөх шаардлага хаанаас ч тавихгүй ирсэн тул арга барилаа өөрчлөх шаардлага байхгүй, шинээр тавигдаж эхэлсэн шаардлагыг аргалах хэлбэрээр “эвлэрүүлэх” зорилготой ажиллаж байна.

- Шилжүүлэн суурьшуулах тухай гэрээг жигд бус, ялгаварлах байдлаар хэрэгжүүлэх, малчдын хооронд хардалт сэрдэлт бий болгох, ажлын байраар хангах заалтыг өөрчлөхдөө гэрээг ил тод бус байлгах, зөвлөгөө авах боломж олгохгүй, үндсэн гэрээнд гарын үсэг зурсан эзэнд үзүүлэхгүй гэрээний заалт өөрчлөх г.м. томоохон зөрчилтэй хэрэгжиж байгааг тогтоож энэ асуудлаар компанитай хэлцэл хийхэд дэмжлэг үзүүлж ирсэн.
- Гэрээний хэрэгжилт хангалтгүй, амьжиргаанд учирсан сөрөг нөлөөллийг тогтоох аргачлал буруу, нүүдэлч малчдын бэлчээр ба усны хүртээмжийг харгалзаагүй, нүүдэллэх

боломжийг хаасан асуудлаар 2012 оны 10-р сард ОУСК-ийн САО гомдол гаргаж 2013 оны туршид сар бүр хэлцэл хийсэн ч нөлөөллийг зөв тогтоох ажил хийгдээгүй байна.

- САО-ийн гомдлын хэлцлийн хүрээнд үрэгдсэн бэлчээрийг хэмжиж тогтоох, малчин өрх тус бүрт үлдсэн бэлчээрийг тоо хэмжээ болон чанарын хувьд үнэлүүлэх, улмаар мал маллагаагаар амьжиргаа залгуулах боломжид хэрхэн нөлөөлснийг тогтоолгох үнэлгээ хийх ажил хэлцлийн шатанд ороод жил гаран болж байна.
- Уурхайн талбайд орсноос зайлшгүй нүүх болсон өрхүүдийг нүүлгэхдээ уурхай тэлэх, нэмэлт дэд бүтэц барьж байгуулах тухай мэдээллээ өгөлгүй нүүлгэснээс өнөөдөр огт бэлчээргүй болсон, ойрын ирээдүйд бэлчээргүй болох малчдын тоо нэмэгдэж байгааг харгалзан мал маллагаагаар амьдрах боломжгүй болсон өрхүүдийн асуудлыг шийдүүлэх санал гомдолд тусгагдсан ч компани огт хүлээн зөвшөөрөхгүй байсаар байна. 2004 оны гэрээний 5.4-т шинээр бий болох нөлөөллийн асуудлаар тусдаа хэлэлцэнэ гэсэн боловч энэ ажлыг орон нутгийн захиргаа хариуцна, ЗД-ын мэдэлд ажлын хэсэг байгуулна хэмээн Рио Тинтогийн зөвлөх шахсаар үр дүнд хүрээгүй зогсоод байна.
- Нүүлгэн шилжүүлсэн айлуудыг шинэ нутагт бууснаар сэтгэл санаа, эдийн засгийн хувьд хэрхэн өөрчлөлт орж хуучин байдлаасаа дээрдсэн эсвэл дордсон эсэхийг эргэж үзээгүй, тэдэнтэй эргэх холбоо тогтоогоогүй, эргэж үнэлгээ хийх дэмжлэг үзүүлээгүй, нөхөн олговрыг нэмэхгүй, эргэж сөхөхгүй гэсэн байр суурьтай хэлцэл хийж байна.

IV. Нутгийн бүлгүүдийн сонирхлыг харгалзах, оролцуулах, саналыг авах, хамгаалах

1. Нүүдэлч малчин өрхүүдийн уламжлалт байгалийн баялаг ашиглах эрх зөрчигдсэн бөгөөд энэ нь НҮБ-ын Уугуул иргэдийн тунхаглалын хүрээнд хамгаалагдсан эрх болно. Энэ асуудлаар 2012 оны гомдолд тусгаж олон нийтийн анхаарлыг хандуулах ажиллагаа хэрэгжүүлсэн. НҮБ-ын Уугуул иргэдийн асуудал эрхэлсэн Тусгай илтгэгчийн зөвлөх, хүний эрхийн хурлууд дээр мэдээлэл хийх, туршлага солилцох, харилцаа холбоо тогтоох ажлууд хийгдсэн.

2. 2013 оны Ундайн голын голдрилыг өөрчлөх төлөвлөгөө нь олон улсын болон үндэсний хууль журмуудыг зөрчсөн, инженерийн хувьд батлагдаагүй төлөвлөгөөтэй, нутгийн иргэдийн ундны усыг хаах үр дагавартай, нутгийн иргэдийн зөвшөөрөлгүй хийж байгааг орон нутаг, үндэсний ЗГ болон Дэлхийн банк зэрэг санхүүжүүлэгчдийн анхаарлыг хандуулах зорилготой нөлөөллийн үйл ажиллагаа хэрэгжүүлсэн. Ханбогд сумын малчдын төлөөлөл Д. Намсрай, Л. Батцэнгэл нарыг Дэлхийн банкны Захирлуудтай уулзаж малчдын дуу хоолой хүргэх ажлыг Банкны Мэдээллийн Төв \BIC\-тэй хамтран зохион байгуулсан.

3. Оюу Толгой, Таван Толгойн замууд, дэд бүтцийн барилгын хэрэгцээний карьеруудын зөвшөөрөл олгохдоо малчдын саналыг авахгүй, амьжиргааг нөхөхгүй, өргөдлийг шийдвэрлэхгүй сөрөг нөлөөлөл учруулж улмаар олон улсын стандарт зөрчиж байгааг баримтжуулж, малчдын гомдлын үндсэн дээр энэ асуудлаар ЗГ, орон нутаг болон Дэлхийн Банк, ЕСБХБ-нд анхааруулах, ХМХ-ээр олон нийтэд хүргэх нөлөөллийн ажил хэрэгжүүлсэн.

➤ Хүний эрх, байгаль хамгааллын ТББ-ын сүлжээнд нэгдэн хамтын ажиллагааг хөгжүүлэх

Оюу Толгойн Хяналт ТББ нь үндэсний байгаль хамгаалах байгууллагуудын МБОИЗ-ийн гишүүн, хөгжлийн өргөн хүрээний асуудлуудаар ажилладаг ИНБ-ын МОНФЕМНЕТ сүлжээний гишүүн бөгөөд 2011 оны 11 сард байгуулагдсан бүсийн Хил хязгааргүй гол мөрөн сүлжээний

гишүүн болно. Эдгээр сүлжээнүүдийн хүрээнд хамтарсан үйл ажиллагаа явуулж ирсэн тухай тайлангийн холбогдох хэсгүүдэд багтаасан болно.

➤ Хүний эрх, байгаль хамгааллын олон улсын ТББ-ын сүлжээнд нэгдэн хамтын ажиллагааг хөгжүүлэх

Оюу Толгойн Хяналт ТББ нь ЭЗХХБ-ын үйл ажиллагааг хянах OECD Watch сүлжээнд 2010 онд Оюу Толгой төслийн тогтвортой байдлын асуудлаар гомдол гаргаж хамтын ажиллагааг эхлүүсэн юм. 2011 онд тус сүлжээнд гишүүнээр элсэн энэ байгууллагын төслийн тэтгэлэгт хөтөлбөрт хандан санал оруулж 2011 оны 11 дүгээр сард 2012 оны 1 улиралд хэрэгжүүлж дуусгах олон улсын гомдлын механизмд гомдолд гаргах төсөл авсан бөгөөд 12 сараас уг төсөл дээр ажиллаж эхэлсэн болно. Уг гомдлыг гаргахад гадаад ба дотоодын хэд хэдэн ТББ-тай хамтран ажиллах хэлбэрээр хамтын ажиллагааг хоёр болон олон талт хэрэгслүүдийн хүрээнд хэрэгжүүлж байна.

Хүний эрх, байгаль хамгаалагчийн эрхийг хамгаалах зорилгынхоо хүрээнд МГННХ-ний тэргүүн Ц. Мөнхбаяр нарын 7 хүний мөрдөн байцаах шат, шүүх хурдын үеэр эрхийг хангаж байгаа эсэх асуудлаар үндэсний болон олон улсын хүний эрх, байгаль хамгаалах сүлжээгээр дамжуулан нөлөөлөл хийх, байгаль хамгаалагч, хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах эрх зүйн орчин шаардагдаж байгаа асуудлуудаар УИХ, ЗГ болон олон улсын хяналт тавих байгууллагуудад хандаж ажиллаж ирэв.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн UPR-ын хүрээнд МУ-д хандсан зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээний ажлын хэсэгт орж ажиллах, “Уул уурхай –Байгаль орчин -Хүний эрх” чиглэлээр үндэсний болон олон улсын хурал зөвлөлгөөнд оролцох, олон нийтэд мэдээлэл ба сургалт түгээх, эрхийг хамгаалах шүүхийн бус механизмуудын сургалт түгээх, ХМХ-ээр нөлөөллийн ажил хийж ирэв.

2012 оны 10-р сард Улаанбаатарт хуралдсан Уул уурхай ба Хүний эрх хуралд малчдын төлөөллийг бэлтгэж оролцуулах, баримт бичгүүдэд санал өгөх, НҮБ-ын Ажлын хэсэгт мэдээлэл хийх ажлын үргэлжлэл болгон НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн Удирдамжийг хэрэгжүүлэх олон улсын чуулганд 2013 оны 12-р сард оролцож энэ чиглэлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, бодлогын болон эрх зүйн орчин бүрдүүлэх талаар нөлөөллийн ажлыг УИХ, ХМХ-ийн хүрээнд хийж эхлэв.

2011 онд байгуулагдсан Хил Хязгааргүй Гол Мөрөн бүсийн байгууллагын гишүүн болсон бөгөөд энэ чиглэлээр хамтын ажиллагааг эхлүүлж 2013 оны 4-р сард Иркутск хотод хуралдсан Байгаль нуур, Сэлэнгэ мөрний сав газрыг хамгаалах асуудлаар олон улсын эрдэмтдийн хуралд оролцож Сэлэнгэ мөрөн дээр Шүрэн усан-цахилгаан станц, Орхон голын усыг урагш Оюу Толгой, Таван Толгойн хэрэгцээнд татах Орхон-Говь төслүүдийн талаар мэдээлэл хийв.

➤ Орон нутгийн иргэний нийгэмтэй харилцаа хөгжүүлэх, чадавхыг бэхжүүлэх сургалт явуулах

1. Олон улсын байгаль орчин ба хүний эрхийг хамгаалах конвенц, стандартуудыг зөрчсөн тохиолдолд гомдол гаргаж шийдвэрлүүлэх шүүхийн бус механизмуудын талаар сургалт сурталчилгаа явуулах, гомдол гаргах бэлтгэл ажил, гомдол боловсруулах ба холбогдох газруудад гаргахад оролцох, гомдлыг барагдуулах эвлэрүүлэн зуучлах үйл явцад оролцох, малчдын бүлгүүдэд дэмжлэг үзүүлж ирсэн.
2. Малчдын бүлгүүд ТББ байгуулах, төсөл бичиж санхүүжилт авах, уурхайн нөлөөллийг томъёолж тайлбарлах, ТББ-ын хурал бэлтгэх, компани ба орон нутгийн захиргаатай уулзах, албан бичгээр харилцах, уурхайн үйл ажиллагаанд хяналт тавих, зөрчлийг мэдээлэх чадавхыг бэхжүүлэх сургалт зохион байгуулсан.
3. Ханбогд суманд удаа дараа очиж, сургалт, зөвлөлгөөн, зөвлөлдөх уулзалт, хэлцэлд оролцож ажилласан.



ЗУРАГ: АНУ-ын Тайлагналын зөвлөх (Accountability Counsel), Банкны мэдээллийн төв (Bank Information Center) ТББ-даас Ханбогд сумын гомдол гаргасан малчдад хэлцэл хийх сургалт 2 удаа хийв.

➤ Хөрөнгө босгох төсөл боловсруулах, хэрэгжүүлэх

Оюу Толгойн Хяналт ТББ-ын өөрийн үйл ажиллагаа явуулах зорилго бүхий хөрөнгө босгож чадаагүй. Харин нийт 3 төслийн санал боловсруулж донор байгууллагуудад хандаж үүнээс 3 төслийн санхүүжилт авч хэрэгжүүлсэн болно . Үүнд:

Green Grants Fund – ОУСК, ЕСББ зэрэг санхүүгийн байгууллагуудын иргэний мониторинг ба гомдлын механизмын үйл ажиллагааны тухай сургалт зохион байгуулахад – хэрэгжүүлж 2013 оны эхний улиралд хэрэгжүүлж дууссан.

OECD Watch – байгууллагын гишүүний хувьд судалгааны ажилд оролцох тэтгэлэг авч 2012 оны 12-р сард хэрэгжүүлж дууссан.

Хаяг: СБД, Бага Тойруу, 44-6

Имэйл: otwatch@gmail.com

Гар: 976-98905828